

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ**

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан	4
2.1	Оршил.....	4
	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.2	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.4	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.5	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.6	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.7	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.8	Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт	7
2.8.1	Мөнгөн хөрөнгө	7
2.8.2	Авлага.....	7
2.8.3	Бараа материал	8
2.8.4	Үндсэн хөрөнгө.....	9
2.8.5	Өр төлбөр.....	9
2.8.6	Засгийн газрын хувь оролцоо.....	10
2.9	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	10
	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.10	Шилэн дансны мэдээлэл	10
2.11	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.12	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	11
3.	Менежментийн захидал	12
3.1	Авлагын данстай холбоотой асуудал	12
3.2	Бараа материалын данстай холбоотой асуудал.....	12
3.3	Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал	13
3.4	Орлогын данстай холбоотой асуудал.....	13
3.5	Шилэн данстай холбоотой асуудал	13
3.6	Харьяа газруудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал	14
4.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	15
4.1	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	16
4.3	Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	19
5.	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Э.БАТБАЯР ТАНАА

2020.03.25 № 01/847
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,300.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь тооцсон материаллаг байдлын түвшин 419.4 сая төгрөгөөс хэтэрсэн, санхүүгийн тайлагналын оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул хязгаарлалттай санал дүгнэлт өгөв.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ТЭНГИС

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус сангийн Гүйцэтгэх захирал Э.Батбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн дэмжлэгийн зээлийн эргэн төлөлтийг тухай бүр барагдуулах, зээлийн эргэн төлөлтийг улсын төсөвт төвлөрүүлж байх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 10-наас 2020 оны 03 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Мөнхчимэг, Ч.Дашдаваа, гэрээт аудитор Ш.Ичинхорлоо нар гүйцэтгэв.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 01/51 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.2 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн эрхэм зорилго нь Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын удирдамж, үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг бүрдүүлж, хуваарилах замаар үр тарианы үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино гэж тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

“Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам”-д Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь доорх чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан байна. Үүнд:

- Үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх,
- Тариалан эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн удирдлага Засгийн газрын тусгай сангийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журмын дагуу шинэчлэгдсэн байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Axplorer” программ хангамж ашигладаг байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.5 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2018 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 209,677.5 сая төгрөгийн 0.2 хувь буюу 419.4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

2.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгжийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 санхүүгийн тайлан аудитад хамрагдсан, 3 байгууллагад итгэл үзүүлсэн байна.

Аудитад хамрагдсан харьяа 5 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 11,133.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 7,832.7 сая төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 200.3 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 128.9 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,971.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмжийг хүргүүллээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Тайлант онд 2,348.8 мянган төгрөгийн бараа материалын дансны ангиллыг буруу ангилж бүртгэж тайлагнасан.

Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага

Улаан буудайн үр зээлээр худалдах, худалдан авах гэрээний үүргийн хэрэгжээгүй үлдэгдэлд гэрээнд заасны дагуу 2019 оны жилийн эцсийн байдлаар 168.9 сая төгрөгийн алданги тооцоогүй, 26.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг төлүүлэлгүйгээр дэмжлэг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Улаан буудайн үр зээлээр худалдах, худалдан авах гэрээний 1.4 дахь заалт “Худалдан авагч нь үрийн урьдчилгаа 30 хувийн төлбөрийг төлж гэрээ байгуулах.....”, 3.5 дахь заалт “Гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол гэрээнд заасан алданги тооцож төлүүлэх эрхтэй” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Албан шаардлага өгөх

Тариаланчдад олгосон дэмжлэгийн эргэн төлөлт 405.0 сая төгрөгийн орлогоос 128.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-д “Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон

орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ" гэж заасантай нийцэхгүй.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоох

Төсвийн төвлөрүүлэн захирагчид 2,836.6 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 8 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,624.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 5,483.9 сая төгрөгийн алдааг залруулж, 5.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 134.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмжийг хүргүүлээ.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 5,483.9 сая төгрөгийн залруулга хийлээ. Тухайлбал:

- Мөнгөн гүйлгээний тайланд өмнөх оны гүйцэтгэл 271.3 сая төгрөгийг тайлагнаагүй.
- Үр дүнгийн тайланд өмнөх оны гүйцэтгэл 276.9 сая төгрөгийг тайлагнаагүй.
- Өмнөх үеийн үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээ зөрүүтэй 4,935.7 сая төгрөгийг тайлагнасан байна.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,927.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 246.1 сая төгрөг болж, 1,681.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Кассанд байгаа бэлэн мөнгө	0	0	0
Банканд байгаа бэлэн мөнгө	1,927.8	246.1	-1,681.7
Дүн	1,927.8	246.1	-1,681.7

Эх сурвалж: Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 246.1 сая төгрөгөөс 246.0 сая төгрөг арилжааны банкны дансанд, 0.1 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна. Үүнээс Төв Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.1 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 4.9 сая төгрөг арилжааны банканд нийт 5.0 сая төгрөг байна. Бага оврын тракторын төслийн арилжааны банкны үлдэгдэл 241.1 сая төгрөг байна.

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 211,788.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 197,683.5 сая төгрөг болж, 14,104.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.4	0.2	-0.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	116,899.3	121,885.3	4,986.0
Татаас, санхүүжилтийн авлага	66.4	0.9	-65.5

Байгууллагаас авах авлага	23,493.3	21,777.0	-1,716.3
Хувь хүмүүсээс авах авлага	151.2	101.2	-50.0
Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	71,177.8	53,918.9	-17,258.9
Дүн	211,788.4	197,683.5	-14,104.9

Эх сурвалж: Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төлбөртэй үйлчилгээний авлага

- Тариаланчдад 2018 онд дэмжлэгийн зээлээр олгосон ОХУ-ын бага оврын тракторын 25,399.1 сая төгрөг, үрийн буудайн дэмжлэгийн 17,921.0 сая төгрөг, гурилын үйлдвэрт олгосон улаан буудайн 19,394.0 сая төгрөг, шатахууны дэмжлэг 9,734.1 сая төгрөг, жимс, чацарганын суулгац 8,847.6 сая төгрөгийн зэрэг авлагатай ба тайлант онд ОХУ-ын техник, тоног төхөөрөмжийн зээлийн авлага 6,000.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Байгууллагаас авах авлага

- Бага оврын трактор төсөл 20,324.5 сая төгрөгийн иргэд аж ахуйн нэгжээс авах авлагатай байна.

Хувь хүмүүсээс авах авлага

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ажиллагсдад 2010 онд байрны урьдчилгаа зээл олгосноос 50.0 сая төгрөг төлөгдөж хугацаа хэтэрсэн 101.2 сая төгрөгийн зээлийн авлага байна.

Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл

- КР-1 төслийн 1,533.5 сая төгрөг, КР-2 төслийн 2,262.2 сая төгрөгийн 2009-2015 онуудад үүссэн авлага байна.

2.8.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 53,318.4 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 81,666.1 сая төгрөг болж, 28,347.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	0	0	0
Бэлэн бүтээгдэхүүн	9,057.7	6,414.5	-2,643.2
Хангамжийн материал	377.5	354.7	-22.8
Нөөцийн бараа	43,883.2	74,896.9	31,013.7
Дүн	53,318.4	81,666.1	28,347.7

Эх сурвалж: Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бэлэн бүтээгдэхүүн

- Ургамал хамгааллын бодис 4,017.9 сая төгрөгийн, жимсний суулгац 48.5 сая төгрөгийн, Хүлэмж, хүнсний ногооны төхөөрөмж 77.4 сая төгрөгийн, бусад техник, тоног төхөөрөмж 2,217.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Төв аймаг, Хэнтий, Сүхбаатар аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газруудад 57 ширхэг 470.5 сая төгрөгийн техник тоног төхөөрөмж шилжүүлсэн, Бага оврын трактор төслийн 2,342.1 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийг Тусгай зориулалтын данснаас Нөөцийн бараанд бүртгэсэн дүнгээр тус тус буурсан байна.

Нөөцийн бараа

- Улаан буудайн үр 3,550.5 сая төгрөгийн, хүнсний буудай 12,766.79 сая төгрөгийн, шатахууны нөөц 14.6 сая төгрөгийн, бага оврын трактор 52,107.2 сая төгрөгийн, ОХУ-ын техник, тоног төхөөрөмж 6,135.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- Худаг 322.8 сая төгрөгөөр, бага оврын трактор, тоног төхөөрөмж 65,114.2 сая төгрөгөөр худалдан авсан дүнгээр тус тус өссөн байна.

2.8.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 81,903.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 79,224.5 сая төгрөг болж, 2,679.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	57,178.8	55,909.2	-1,269.6
Авто-тээврийн хэрэгсэл	1,692.4	1,421.8	-270.6
Машин тоног төхөөрөмж	5,427.6	4,462.3	-965.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	184.9	152.3	-32.6
Зам, гүүрийн байгууламж	3,303.0	3,175.1	-127.9
Дуусаагүй барилга байгууламж	3,485.5	3,485.5	0
Үндсэн хөрөнгийн дүн	71,272.2	68,606.2	-2666.0
Программ хангамж	51.9	38.9	-13.0
Бусад биет бус хөрөнгө	10,579.4	10,579.4	-
Биет бус хөрөнгийн дүн	10,631.3	10,618.3	-13.0
Дүн	81,903.5	79,224.5	-2,679.0

Эх сурвалж: Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 37.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн. Үүнээс 28.3 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 9.0 сая төгрөгийн программ хангамж байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сан салбар хооронд балансаас балансад шилжүүлэн авсан 581.4 сая төгрөг, үнэ төлбөргүй болон бусад эх үүсвэрээр авсан 288.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд хөрөнгө актлаагүй байна.

2.8.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 238,095.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 259,038.5 сая төгрөг болж, 20,942.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Төслийн зээл	432.6	569.1	136.5
Ажилчидтай холбогдсон өглөг	4.8	3.3	-1.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,034.1	0	-2,034.1
Бусад өглөг	134,633.2	88,159.5	-46,473.7
Урьдчилж орсон орлого	440.6	430.7	-9.9
Урт хугацаат зээл	100,550.3	169,875.9	69,325.6
Нийт дүн	238,095.6	259,038.5	20,942.9

Эх сурвалж: Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

- Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 11,053.5 сая төгрөгийн, Ник ХХК-д 5,228.9 сая төгрөгийн, Ди Би Эм лизинг ХХК-д 39,223.8 сая төгрөгийн, Бага оврын трактор төсөлд 20,324.5 сая төгрөгийн өглөгтэй байна.
- ОХУ-с оруулж ирсэн техник тоног төхөөрөмжийн үнийн ханшийн зөрүүний гарз үүссэнтэй холбоотойгоор 4,334.4 сая төгрөгөөр өглөг нэмэгдсэн.

Урт хугацаат өр төлбөрийн дүн нь 70,385.6 сая төгрөгөөр нэмэгдсэн. Үүнд:

- БНХАУ-аас трактор, техник тоног төхөөрөмж худалдан авсан бөгөөд тайлант онд 65,114.2 сая төгрөгөөр, ханшийн зөрүүний гарз 5,271.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

2.8.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 113,184.8 сая, эцсийн үлдэгдэл 99,781.9 сая төгрөг болж, 13,402.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	77,529.7	77,529.7	-
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	3,600.5	3,600.5	-
Хуримтлагдсан үр дүн	15,887.7	2,484.8	-13,402.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,166.9	16,166.9	-
Дүн	113,184.8	99,781.9	-13,402.9

Эх сурвалж: Засгийн газрын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 35,267.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 17,225.6 сая төгрөгийг урсгал зардалд, 12,800.0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын зардалд зарцуулахаар батлагдсан.

Нийт зардлын 13,026.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 38,998.8 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 16,757.7 сая төгрөгийг дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөхөөр төлөвлөжээ.

Дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөхөөр 2019 оны төсөвт 16,757.7 сая төгрөг батлагдсанаас Сангийн сайд, ХХААХҮС-ын Төлбөр барагдуулах гэрээний дагуу 10,000.0 сая төгрөгийг төлж 76.3 хувийн биелэлттэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 32,495.9 сая төгрөг буюу 92.1 хувийн биелэлттэй.

ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХҮЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Худалдан авах ажиллагаа, Тариалан эрхлэлтийг дэмжих сангаас олгож буй дэмжлэгийн зээлийн эргэн төлөлт, авлага, өглөгийн барагдуулалт, урамшуулал олголт, төслийн зарцуулалт, хөрөнгийн хадгалалт хамгаалалтын талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.10 Шилэн дансны мэдээлэл

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 88 мэдээллийг хугацаанд нь 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагчид 1 зөвлөмж, 4 албан шаардлагыг өгсөн байна.

Нийт 1 зөвлөмж, 3 албан шаардлагыг хэрэгжүүлж, 1 албан шаардлага хэрэгжих шатанд, зөвлөмжийн хэрэгжилт 83.3 хувьтай байна.

2.12 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлагын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Үрийн буудай, ургамал хамгааллын бодис, бордоо, дизель түлшний дэмжлэгийг тариаланчдад олгож, гэрээнд зааснаар тайлант оны 12 сард багтаан мөнгөөр болон улаан буудайгаар буцаан төлүүлэхээр тусгасан боловч, гэрээний дагуу үүссэн авлага, өглөгийг тооцоо нийлсэн акт үйлдэж баталгаажуулаагүй байна. Уг авлагаас 39,791.9 сая төгрөгийн авлагыг барагдуулахаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн, 2,099.8 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн байгаа нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсөвт төвлөрүүлэх зээлийн эх үүсвэр төлөгдөхгүй байх, найдваргүй авлага нэмэгдэх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Дэмжлэгийн эргэн төлөлтийг тухай бүр барагдуулж, эргэн төлөлтөө хийхгүй байгаа аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх, дотоод хяналтаа сайжруулах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Бараа материалын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Нөөцийн барааны тооцсон хэвийн хорогдол болон хэрэглээний шаардлага хангахгүй болсон нийт 17.1 сая төгрөгийн бараа материалыг акталж устгах тухай байгууллагын даргын шийдвэргүйгээр данснаас хассан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.1-д "Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хөрөнгө хяналтгүй зарагдах, хууль тогтоомжийг мөрдөж ажиллахгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нөөцийн улаан буудайн хэвийн хорогдол, шаардлага хангахгүй болсон бараа материалыг актлахдаа тооллогын комиссын шийдвэрийн дагуу тариалан эрхлэлтийг дэмжих сангийн захирлын тушаал гаргаж, хяналт тавих

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Булган, Сэлэнгэ, Хөтөл салбаруудад тайлант оны төсөвт тусгаагүй 201.6 сая төгрөгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлсэн, 16.6 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 70.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус авлагад тооцон авч, бүртгэж тайлагнасан нь Улаан буудайн үр зээлээр худалдах, худалдан авах гэрээний 1.4-д "Худалдан авагч нь үрийн урьдчилгаа 30 хувийн төлбөрийг төлж гэрээ байгуулах ба үлдэгдэл 70 хувийн төлбөрийг бэлэн мөнгөөр болон хүнсний улаан буудайгаар төлнө" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Улсын төсвийн эх үүсвэрээс санхүүжүүлсэн зээлээр барилга угсралтын ажил гүйцэтгүүлсэн нь зээлийн эх үүсвэрийг буцаан улсын төсөвт төвлөрүүлэхгүй байх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Зээлийн эргэн төлөлтийг улсын төсөвт төвлөрүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4 Орлогын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Урьдчилж орсон орлого дансанд эзэн холбогдогч нь тодорхойгүй 430.7 сая төгрөгийн орлогыг жил бүр хуримтлуулан бүртгэсэн боловч тухай бүр ААНБ, иргэдтэй тооцоо нийлж уг орлогыг бууруулах арга хэмжээ аваагүйгээс авлага, өглөг нэмэгдэх нөхцлийг бий болгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Үр дүнгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Урамшуулал авч буцаан төлөлт хийж буй харилцагчидтай тооцоо нийлж, эзэн холбогдогчийг тодруулж өглөгийг тухай бүр барагдуулах, ажлын хариуцлагыг сайжруулах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.5 Шилэн данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.1.2 Эрсдэл:

Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаагүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль журмыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.6 Харьяа газруудад илэрсэн алдаа, зөрчилтэй холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Харьяа газруудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,624.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 5,483.9 сая төгрөгийн алдааг залруулж, 5.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 134.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

3.3.2 Эрсдэл:

Дотоод хяналт хангалтгүй байх, хууль тогтоомж зөрчигдөх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Харьяа газруудад өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавих, зөрчлийг давтан гаргуулахгүй байхад анхаарч ажиллах.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2020 оны 9 дүгээр сарын 10-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	269,377,284.5	279,596,155.4
МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,927,889.5	246,119.5
АВЛАГА	211,788,687.1	197,683,812.1
БАРАА МАТЕРИАЛ	11,777,427.8	6,769,297.0
НӨӨЦИЙН БАРАА	43,883,280.2	74,896,926.8
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	81,903,541.8	79,224,459.7
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	81,903,541.8	79,224,459.7
Биет хөрөнгө	71,272,152.3	68,606,107.1
Биет бус хөрөнгө	10,631,389.5	10,618,352.7
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	351,280,826.3	358,820,615.1
НИЙТ ӨР ТӨЛБӨР	238,095,961.2	259,038,701.4
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	137,545,626.8	89,162,786.3
Богино хугацаат зээлийн өглөг	432,669.2	569,124.6
Өглөг	136,672,314.3	88,162,873.4
Урьдчилж орсон орлого	440,643.3	430,788.3
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	100,550,334.4	169,875,915.1
Урт хугацаат зээл	100,550,334.4	169,875,915.1
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	113,184,865.1	99,781,913.8
Засгийн газрын хувь оролцоо	113,184,865.1	99,781,913.8
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	77,529,741.2	77,529,741.2
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	3,600,480.0	3,600,480.0
Хуримтлагдсан үр дүн	15,887,706.4	2,484,755.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	16,166,937.5	16,166,937.5
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	351,280,826.3	358,820,615.1

4.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	46,114,764.5	19,712,260.5
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,102,564.5	6,685,395.5
Нийтлэг татварын бус орлого	31,102,564.5	6,685,395.5
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,012,200.0	13,026,865.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	21,444,336.2	23,246,289.2
УРСГАЛ ЗАРДАЛ	21,444,336.2	23,246,289.2
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	11,384,568.9	10,215,470.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,412,357.8	1,603,047.1
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	172,374.6	207,068.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	252,868.7	249,166.0
Хангамж, бараа материалын зардал	718,206.2	461,226.9
Нормативт зардал	7,942.8	4,663.6
Эд хогшил, урсгал засварын зардал	139,641.0	159,451.0
Томилолт, зочны зардал	57,589.6	105,319.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,496,914.6	2,412,783.7
Бараа үйлчилгээний бусад зардал	3,126,673.6	5,012,743.5
ТАТААС	9,869,537.1	13,014,798.7
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	190,230.2	16,020.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	24,670,428.3	-3,534,028.7
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	13,646.4	504,190.2
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	41,575,008.2	8,763,646.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-16,890,933.5	-11,793,485.4

4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	23,899,525.5	35,726,303.6
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,854,954.7	32,699,438.6
Нийтлэг татварын бус орлого	32,854,954.7	32,699,438.6
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-8,955,429.2	3,026,865.0
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,876,639.6	20,862,806.6
УРСГАЛ ЗАРДАЛ	27,876,639.6	20,862,806.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,656,929.9	7,566,200.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,411,164.6	1,585,995.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	169,990.5	209,721.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	254,494.9	260,461.8
Хангамж, бараа материалын зардал	104,339.0	116,928.5
Нормативт зардал	6,413.6	5,997.3
Эд хогшил, урсгал засварын зардал	109,673.4	101,461.6
Томилолт, зочны зардал	59,713.0	105,319.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,323,462.8	4,986,085.9
Бараа үйлчилгээний бусад зардал	5,217,678.3	194,229.4
ТАТААС	14,963,000.0	13,003,465.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	256,709.7	293,140.8
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-3,977,114.1	14,863,496.9
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	5,589,350.8	11,920,821.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,589,350.8	11,920,821.0
Дотоод эх үүсвэрээр	5,589,350.8	11,920,821.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-5,589,350.8	-11,920,821.0
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-2,808,246.4	-4,624,445.9
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,808,246.4	4,624,445.9
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-12,374,711.3	-1,681,770.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,302,600.8	1,927,889.5
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,927,889.5	246,119.5

4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,454,552.2	0.0	114,454,552.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-9,092,962.9	0.0	-9,092,962.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	105,361,589.3	0.0	105,361,589.3
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	15,782,655.7	0.0	15,782,655.7
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	8,931,553.5	0.0	8,931,553.5
Тайлант үеийн үр дүн	-16,890,933.5	0.0	-16,890,933.5
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	113,184,865.1	0.0	113,184,865.1
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	113,184,865.1	0.0	113,184,865.1
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,609,465.9	0.0	-1,609,465.9
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	111,575,399.2	0.0	111,575,399.2
Тайлант үеийн үр дүн	-11,793,485.4	0.0	-11,793,485.4
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,781,913.8	0.0	99,781,913.8

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	35,267,949.5	32,495,942.9	2,772,006.6	92.1
УРСГАЛ ЗАРДАЛ	17,225,689.1	17,048,045.4	177,643.7	99.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,203,274.1	4,028,560.4	174,713.7	95.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,704,538.8	1,585,995.2	118,543.6	93.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	214,317.3	209,721.3	4,596.0	97.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	290,670.7	260,461.8	30,208.9	89.6
Хангамж, бараа материалын зардал	119,461.7	116,928.5	2,533.2	97.9
Нормативт зардал	6,524.0	5,997.3	526.7	91.9
Эд хогшил, урсгал засварын зардал	112,974.3	112,250.1	724.2	99.4
Томилолт, зочны зардал	62,331.6	62,008.4	323.2	99.5
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,690,859.8	1,673,601.9	17,257.9	99.0
Бараа үйлчилгээний бусад зардал	1,595.9	1,595.9	0.0	100.0
ТАТААС	13,003,465.0	13,003,465.0	0.0	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	13,003,465.0	13,003,465.0	0.0	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,950.0	16,020.0	2,930.0	84.5
Бусад урсгал шилжүүлэг	18,950.0	16,020.0	2,930.0	84.5
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,800,000.0	11,883,451.5	916,548.5	92.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,242,260.4	3,564,445.9	1,677,814.5	68.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	35,267,949.5	32,776,830.2	2,491,119.3	92.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,026,865.0	13,026,865.0	0.0	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	38,998,824.1	29,749,965.2	9,248,858.9	76.3
БУСАД ЭХ ҮҮСВЭР	-16,757,739.6	-10,000,000.0	-6,757,739.6	59.7
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	331	327	4	98.8
БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	0	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	164	162	2	98.8
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	164	162	2	98.8

Хавсралт

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит	Аудитын код:
2019 он			САГ-2020/02/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын	Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит		Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	Авлагын 1 хувь буюу 2,099.8 сая төгрөгийн авлага хугацаа хэтэрсэн, 20 хувь буюу 39,791.9 сая төгрөгийн авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.	2,099.8	Зөвлөмж	ТЭДС-ийн гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Тооцооны нягтлан бодогч	В.Үнэнбат, Б.Сосорбарам, Ж.Мөнхтуяа, А.Энхжаргал
2	Нөөцийн барааны тооцсон хэвийн хорогдол болон хэрэглээний шаардлага хангахгүй болсон нийт 17.1 сая төгрөгийн бараа материалыг акталж устгах тухай байгууллагын даргын шийдвэргүйгээр данснаас хассан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.1-д "Худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх" гэж заасантай нийцэхгүй байна.	17.1	Зөвлөмж	ТЭДС-ийн гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Тооцооны нягтлан бодогч	В.Үнэнбат, Б.Сосорбарам, С.Удвал
3	Булган, Сэлэнгэ, Хөтөл салбаруудад тайлант оны төсөвт тусгаагүй 201.6 сая төгрөгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгүүлсэн, 16.6 сая төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, 70.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус авлагад тооцон авч, бүртгэж тайлагнасан нь Улаан буудайн үр зээлээр худалдах, худалдан авах гэрээний 1.4-д "Худалдан авагч нь үрийн урьдчилгаа 30 хувийн төлбөрийг төлж гэрээ байгуулах ба үлдэгдэл 70 хувийн төлбөрийг бэлэн мөнгөөр болон хүнсний улаан буудайгаар төлнө" гэж заасантай нийцэхгүй байна.	289.0	Зөвлөмж	ТЭДС-ийн гүйцэтгэх захирал, Хуулийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	В.Үнэнбат, Т.Төгөлдөр, Б.Сосорбарам
4	Урьдчилж орсон орлого дансанд эзэн холбогдогч нь тодорхойгүй 430.7 сая	430.7	Зөвлөмж	ТЭДС-ийн гүйцэтгэх	В.Үнэнбат, Б.Сосорбарам,

	төгрөгийн орлогыг жил бүр хуримтлуулан бүртгэсэн боловч тухай бүр ААНБ, иргэдтэй тооцоо нийлж уг орлогыг бууруулах арга хэмжээ аваагүйгээс авлага, өглөг нэмэгдэх нөхцөлийг бий болгосон.			захирал, Ерөнхий нягтлан бодогч, Тооцооны нягтлан бодогч	Ж.Мөнхтуяа, А.Энхжаргал
5	Тариалан эрхлэлтийг дэмжих сан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 19 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.		Зөвлөмж	ТЭДС-ийн гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Тооцооны нягтлан бодогч	В.Үнэнбат, Б.Сосорбарам, С.Удвал
6	Улаан буудайн үр зээлээр худалдах, худалдан авах гэрээний үүргийн хэрэгжээгүй үлдэгдэлд гэрээнд заасны дагуу 2019 оны жилийн эцсийн байдлаар 168.9 сая төгрөгийн алдагдлыг тооцоогүй, 26.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг төлүүлэлгүйгээр дэмжлэг олгосон.	195.0	Албан шаардлага	ТЭДС-ийн гүйцэтгэх захирал, Хангамжийн хэлтсийн дарга, Ерөнхий нягтлан бодогч	В.Үнэнбат, Б.Отгонбаяр, Б.Сосорбарам, С.Удвал
7	Тариаланчдад олгосон дэмжлэгийн эргэн төлөлт 405.0 сая төгрөгийн орлогоос 128.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй.	128.9	Төлбөрийн акт	ТЭДС-ийн гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Тооцооны нягтлан бодогч	В.Үнэнбат, Б.Сосорбарам, Ж.Мөнхтуяа
8	Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,624.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 5,483.9 сая төгрөгийн алдааг залруулж, 5.3 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 134.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өглөө.	140.1	Харьяа газруудад илэрсэн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх, талаар анхаарч ажиллах зөвлөмж өгөх	Төсвийн шууд захирагчид	Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн харьяа газар дарга нар
	Дүн	3,300.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 03 дугаар сарын 25 № 01/195
СЭН 2020/02/СТА-ЗГТС

Улаанбаатар хот

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасан цаглабарт хугацаанд Хөдөө аж ахуйг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улаанбуудайн үр зээлээр худалдах, худалдан авах гэрээний үүргийн хэрэгжээгүй үлдэгдэлд гэрээнд заасны дагуу 2019 оны жилийн эцсийн байдлаар 168.9 сая төгрөгийн алдагдлыг тооцоогүй, 26.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг төлүүлэлгүйгээр дэмжлэг олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Улаан буудайн үр зээлээр худалдах, худалдан авах гэрээний 1.4 дахь заалт "Худалдан авагч нь үрийн урьдчилгаа 30 хувийн төлбөрийг төлж гэрээ байгуулах.....", 3.5 дахь заалт "Гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй бол гэрээнд заасан алданги тооцож төлүүлэх эрхтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

1. Гэрээг дүгнэж, алдангийг тооцон, хэрэгжилтийг ханган ажиллах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.
2. Биелэлтийг 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Э.Батбаяр, Ерөнхий нягтлан бодогч Б.Сосорбарам нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ:

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР Ч.ДАШДАВАА

АУДИТОР Г.МӨНХЧИМЭГ

ЗӨВШӨӨРСӨН:

ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ
САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Э.БАТБАЯР
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Б.СОСОРБАРАМ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.NR\Richie_Kherep\Alban Shaardlaga\2020\0325SAG77.Docx

001080673



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 25

№ 01/87

Улаанбаатар хот

СНГ- 2020/02/СТА-ЗГТС

Орлого төвлөрүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасан цаглабарт хугацаанд Хөдөө аж ахуйг дэмжих сангийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тариаланчдад олгосон дэмжлэгийн эргэн төлөлт 405.0 сая төгрөгийн орлогоос 128.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-д "Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээсэлсний орлого, торгуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусламж болон хууль тогтоомжийн дагуу төсөвт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ", 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" Хүнсний буудайнд урамшуулал олгох журмын 1.7 дахь заалтад "Хэрэв Хүнс хөдөө, аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам нь Сангийн яаманд гэрээгээр хүлээсэн өглөгтэй ба тэрхүү өглөгийг урамшуулал авах этгээдүүдэд зээлдүүлсэн байх тохиолдолд урамшууллын мөнгөнөөс зохих авлагыг Сангийн яам суутган авч болно" гэж заасантай тус тус нийцэхгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх ...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1-д заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нийт 128.9 сая төгрөгийг Үндэсний аудитын газрын Төв төрийн сан дахь 100900000601 тоот дансанд 2020 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор төвлөрүүлэх.
2. Биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөө аж ахуйг дэмжих сангийн гүйцэтгэх захирал Э.Батбаяр, Ерөнхий нягтлан бодогч Б.Сосорбарам нарт даалгав.

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР Г.МӨНХЧИМЭГ

АУДИТОР Ч.ДАШДАВАА

АКТЫГ:

ЗӨВШӨӨРСӨН:

ХӨДӨӨ АЖ АХУЙГ ДЭМЖИХ
САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Э.БАТБАЯР

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Б.СОСОРБАРАМ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь талх тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харуулагч албан тушаалтанд харууллаа тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Bichie_Kherep\Akt\2020\032554612 Docx

001090254